

СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2007 оны 10 сарын 10

№ 69

ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. “Сэлэнгэ зөгий” хөтөлбөрийг 1-р хавсралтаар, “Өрхийн аж ахуйд зөгийн аж ахуй эрхлэх зөвлөмж”-ийг 2-р хавсралтаар тус тус баталсугай.
2. Хөтөлбөрийг сурталчилж, хэрэгжүүлэх талаар үр дүнтэй, тодорхой ажил зохион байгуулахыг аймаг, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ДАРГА

Х. ЖАВХЛАН

## **“СЭЛЭНГЭ ЗӨГИЙ“ ХӨТӨЛБӨР**

### **Нэг. Зөгийн аж ахуйн одоогийн байдал**

Манай аймаг 1959 онд Буриад улсаас Дундад Оросын бараан саарал үүлдрийн 20 бүл зөгий импортлож, Шаамар суманд үржүүлж эхэлснээр зөгийн аж ахуйн суурь тавигдсан.

1982 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн тогтоолоор Зөгий үржүүлгийн газар болгож өргөжүүлсэн. Тус зөгий үржүүлгийн газар нь үржлийн 1, таваарын 3 фермтэй 2800 бүл зөгийтэй, 80 гаруй ажилчидтай, жилд 20-25 тн зөгийн бал үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлэхийн дээр эх зөгий, бүлэнцэр гаргаж, иргэд, аж ахуйн нэгжийг хангаж байв.

Зах зээлд шилжсэн жилүүдэд зөгийн аж ахуйд төр засаг, үржүүлэгч эздийн тавих анхаарал суларч бүлийн тоо, авах бүтээгдэхүүний хэмжээ эрс буурч, материаллаг бааз нь тоногдож устахад хүрч байна.

2007 оны байдлаар Шаамар, Мандал, Сүхбаатар, Алтанбулаг, Баруунбүрэн суманд 600 гаруй бүл зөгий үржүүлж жилд дунджаар 5.3-5.7 тонн бал үйлдвэрлэж 1 бүлээс 9 кг бал авч байна.

Эрдэмтэдийн судалгаагаар манай аймагт 60 гаруй овгийн 200 балт, тоост ургамалтай нь тогтоогдсон байна.

Манай аймагт 150 бүл зөгийтэй нэг аж ахуй нэгж 15-17 тн бал хэрэгтэйг судалгаагаар тогтоосон.

Физиологийн нормоор нэг хүнд жилд 1.8 кг цэвэр зөгийн бал хэрэгтэйг судалгаагаар тогтоосон.

Манай аймагт дээрх нормоор тооцвол 165.4 тн бал шаардагдана.

2006 онд 4.4 тонн бал үйлдвэрлэснээс үзвэл нэг хүнд 47 гр бал ногдож байгаа нь аймгийн хүн амын хэрэгцээт балны 2.6 хувийг хангаж байна.

2005 онд Австрали, Франц, Польш, Герман, Орос, Солонгос, Аргентин зэрэг орноос 76 тонн бал импортолж байсан.

Энэ нь зөгийн балны хэрэгцээг илтгэх нэг үзүүлэлт юм.

### **Хоёр. Зөгийн аж ахуйн ач холбогдол**

Зөгийн аж ахуйгаас олон төрлийн бүтээгдэхүүн авч хүнс ,болон эмчилгээ сувилгаанд ашиглахаас гадна ургамлын тоос хүртээхэд ашигласнаар ургацын 40-50. хувь дээшлүүлж, үр жимс, ногооны чанарт сайн нөлөө үзүүлдэг.

Зөгийн аж ахуйгаас гардаг бал лав, сүүнцэр, жилий, тоосомцор хор гэх мэт бүтээгдэхүүн нь хүнс, тэжээл, эмчилгээ сувилгаа,үйлдвэр, хөдөө аж ахуй, сансар судлал зэрэг олон салбарт хэрэглэгдэж байна.

Зөгийн бүтээгдэхүүнийг эрт дээр үеэс хүн төрөлхтөн олон төрлийн өвчнийг анагаах, түүнээс урьдчилан сэргийлэх бие мах бодийг чийрэгжүүлэх зорилгоор хэрэглэж ирсэн. Зөгийн бал сүүнцэрийг эмчилгээний журмаар хэрэглэх нь урт наслах гол үндэс гэж эрдэмтэд баталсан байна.

Бал нь микро элементээр баялаг учир бодсын солилцоог идэвхижүүлж, дотоод шүүрлийн булчирхайн үйл ажиллагааг сэргээж, улаан, цагаан цогцосыг нэмэгдүүлж, өвчин эсэргүүцэх чадварыг сайжруулдаг.

Зөгийн бал эмчилгээний ач холбогдолтойгоос гадна, хоол тэжээлийн чухал бүтээгдэхүүн бөгөөд бие махбодийг микро элемент, витамин амин хүчлээр хангаж, гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөн, дотоод шүүрлийн үйл ажиллагааг идэвхижүүлдэг.

Мөн хүний биеийн ерөнхий байдал, зүрхний ажиллагааг сайжруулан, ходоодны шүүсний хүчиллэгийг хэвийн болгож цус багадалт, бамбай булчирхайн хордлого, элэгний эдийн гэмтэл, туяаны эмчилгээнд хэрэглэдэг.

Лавыг сэмж хийхэд ашиглахаас гадна радиотехник, нисэх онгоц, хими, нэхмэл, мебель зэрэг 40 гаруй үйлдвэрүүдэд ашигладаг.

Тоосормог нь цусан дахь улаан, цагаан цогцосыг нэмэгдүүлдэг бөгөөд ходоод гэдэсний хэвийн үйл ажиллагааг хангаж, ажиллах чадварыг дээшлүүлдэг.

Жилийг уушигний сүрьеэ, арьсны янз бүрийн өвчин, төрөл бүрийн шарх, шүд, чих, хамар хоолойг эмчлэхэд өргөн хэрэглэнэ.

Зөгийн сүүнцэр нь хүний биеийн бодисын солилцоог сайжруулан ядаргааг арилгах ба дотоод шүүрлийн булчирхайн үйл ажиллагааг идэвхижүүлнэ.

Зөгийн хороор багтраа, булчингийн хэрх, цусны даралт ихсэх, судасны хана хатуурах, бамбай булчирхай, арьсны өвчнүүдийг эмчилдэг.

### **Гурав. Хөтөлбөр боловсруулах шаардлага, үндэслэл.**

Улсын Их хурлын 2003 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын баримт бичигт дотоод зах зээлийн

эргэлт хэрэгцээнд нийлүүлж чанар сайтай аюулгүй бүтээгдэхүүн нийлүүлэх” аймгийн засаг даргын 2004-2008 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Гахай, шувуу, туулай, зөгийн аж ахуйг хөгжүүлэх, үржлийн мал төлөөр хангах загвар аж ахуй бий болгоход дэмжлэг үзүүлнэ” гэж заасан.

Түүнчлэн аймгийн ИТХТ-ийн тогтоолоор баталсан “Эрчимжсэн мал аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх хөтөлбөр”, “Бэлчээр ашиглалт, хамгаалалт, усан хангамжийг сайжруулах” хөтөлбөр зэрэгт Зөгийн аж ахуйг хөгжүүлэх бүс нутгийг тогтоож, бэлчээр ашиглуулах, эзэмшүүлэх асуудлыг тодорхойлж өгсөн зэрэг баримт бичгийг зөгийн аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэхийг тодорхой заасан байна.

Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлж хүн амын эрүүл мэндэд чухал хэрэгцээтэй зөгийн бал болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, иргэдийн хэрэгцээг хангах нь тулгамдсан зорилт болж байна.

Зөгийн аж ахуйн бүтээгдэхүүн улирлын чанартай байдаг боловч өөрийн аймгийн нөхцөлд тохирсон тэсвэртэй найдвартай бүтээгдэхүүн өгдөг үүлдрийн зөгийг үржүүлэх шаардлагатай.

Сүүлийн жилүүдэд ард иргэд аж ахуй нэгжүүдийн дунд зөгийн аж ахуй эрхлэх сонирхол дээшилж байгаа боловч зөгийн бүлийн олдоц муу, түүнийг эрхлэх дадлага туршлага бага, мэдээллээр хангах ажил хангалтгүйгээс тодорхой үр дүнд хүрэхгүй байна.

Малын тоо хэт их өсөж, бэлчээрийг хуваарьгүй дур зоргоор ашигласнаас зөгийн бэлчээр хомсдож байна.

Дээрх хортой үр дагаварыг арилган, зөгийн аж ахуй талаар сургалт, сурталчилгаа хийж, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хэрэгцээ байна.

Өрхийн аж ахуйд зөгийн аж ахуй эрхэлж таримал болон бэлчээрийн ургацын нэмэгдүүлэх, эмчилгээ сувилгааны чанартай бүтээгдэхүүнээр өрх гэрийнхээ хэрэгцээг хангах улмаар зах зээлд борлуулах боломж байна.

Зөгийн аж ахуй эрхэлснээр өрсөлдөх чадвартай байгалийн цэвэр бүтээгдэхүүн зөгийн бал үйлдвэрлэж дотоодын зах зээлээс хуурамч бал, гадаадын балыг шахан зайлуулах шаардлагатай байна.

### **Дөрөв: Хөтөлбөрийн зорилго зорилт**

Хүн ам өсөн нэмэгдэж байгаа хүнсний хэрэгцээг уураг,витаминаар баялаг,эмчилгээ сувилгааны чанартай зөгийн бал түүний бусад бүтээгдэхүүнээр

хангах, зөгийн аж ахуйг өрхийн аж ахуйн түвшинд хөгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Хөтөлбөрийн үндсэн зорилт.

1. Иргэдийг зөгийн аж ахуй эрхлэх арга барилд сургах.
2. Зөгийн үржлийн аж ахуйг байгуулах.
3. Зөгийн бэлчээрийг зүй зохистой ашиглаж түүний нөхөн төлжих боломжийг бүрүүлэх.
4. Эрдэм шинжилгээний байгууллага эрдэмтэн, мэргэжилтнүүдтэй хамтарч балт ургамлын судалгаа явуулж нөөцийг тогтоох.
5. Бэлчээрт олон наст ургамал тариалж зөгийн бэлчээрийг нэмэгдүүлж ашиглалтыг сайжруулах.

### **Тав: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа**

“Сэлэнгэ зөгий “ хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээг 2015 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

**1 дүгээр шат** /2007-2010 он/ хөтөлбөрийн хэрэгжүүлэх эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээ авч, зөгийн аж ахуйг хөгжүүлэх эхлэлийг тавьж түүний ач холбогдлыг орон нутагт сурталчлах, сургалт зохион байгуулах, иргэдэд зөгийн аж ахуйн технологийн мэдлэг олгох.

**2 дугаар үе шат.** /2011-2015 он/ эхний үе шатын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч нийт өрхийн 30-аас доошгүй хувийг 15-аас доошгүй бүл зөгийтэй болгон бал үйлдвэрлэлийн хэмжээ 108 тн-д хүргэнэ. Үүний тулд эх зөгий бойжуулахын зэрэгцээ гадаадаас зөгий импортлох арга хэмжээ авна. Хөтөлбөрийн хэрэгжилт явц, үр дүнгийн талаар тогтмол мэдээлж иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээг нэмэгдүүлж гадаад дотоодын төсөл хөтөлбөртэй уялдуулах ажлыг үе шаттай зохион байгуулах.

### **Зургаа. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

6.1.Зөгийн арчилгаа маллагааны технологи, үржлийн ажлын талаар ард иргэдийн дунд сургалт зохион байгуулах.

6.2.Зөгийн үржлийн аж ахуй байгуулж, иргэд аж ахуйн нэгжийг эх зөгийгөөр хангах арга хэмжээ авах.

6.3.Зөгий бүхий өрхөд ойрын бэлчээрийг гэрээгээр ашиглуулах

- 6.4.Зөгийд зориулж нэг ба олон наст ургамал тариалах /царгас, хүцэнгэ, наранцэцэг, гурвалжин будаа, хар будаа гэх мэт/
- 6.5.Өвөлжөө хаваржааны бэлчээр, хадлангийн талбайг зөгийн бэлчээрт ашиглах асуудлыг шийдвэрлэх.
- 6.6.Гадаадаас зөгий оруулж ирэх гэрээ хэлэлцээр байгуулж гаалийн болон нэмүү өртгийн албан татварыг хөнгөлөх УИХ, Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх.
- 6.7. Зөгий үржүүлэгчдэд бага хүүтэй урт хугацаатай зээл олгож дэмжлэг үзүүлэх
- 6.8. Зөгийн суурьт мал эмнэлэг ариун цэврийн зааврын дагуу төрөл бүрийн өвчнөөс урьдчилан сэргийлэх ариутгал цэвэрлэгээг тогтмол хугацаанд хийж, халдварт өвчин гарсан тохиолдолд эмчлэн эрүүлжүүлэх ажлыг богино хугацаанд гүйцэтгэх. Үүний тулд зөгийн аж ахуйгаар мэргэшсэн эмч мэргэжилтнийг давтан сургалтаар бэлтгэх
- 6.9.Зөгийн аж ахуйд шинжлэх ухааны ололт, тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, дэлгэрүүлэх, зөгийчдийн ололт амжилтыг бататгах, идэвх санаачлагыг өрнүүлэх, хэвлэл мэдээлэлийн хэрэгслээр сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулах.
- 6.10.Зөгийчдөд хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны талаар сургалт сурталчилгаа хийж, ахуй хангамжийг сайжруулах арга хэмжээ авах.
- 6.11.Зөгийн үржлийн ажил, өвчин хортноос сэргийлэх, эмчлэх, оторлох, балт ургамал тарьж ашиглах зэрэг ажлыг зөгийн аж ахуйн эрдэмтэд, туршлагатай зөгийчдийн заавар зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэх.
- 6.12.Зөгийн аж ахуйд хөтлөгдөх анхан шатны маягтыг тогтмол хөтөлж, зардлыг багасгах, дотоод нөөц бололцоог ашиглаж, арвилан хэмнэлтийг сайжруулан, бал үйлдвэрлэлийн технологи, бүтээгдэхүүний чанарт мэргэжлийн хяналтын байгууллагын зүгээс байнгын хяналт тавьж ажиллах.
- 6.13.Сум орон нутгийн зөгий үржүүлэгч аж ахуйн нэгж, иргэдийн саналыг зөгийчдийг МСҮТөвийн болон богино хугацааны сургалтаар бэлтгэх
- 6.14.Зөгийн бал болон бусад бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээ бий болгох.

### **Долоо. Аймгийн төр захиргааны байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

- 7.1. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор батлагдсан “Сэлэнгэ-зөгий” хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, эрх зүйн үндсийг боловсронгуй болгох.
- 7.2 Аймаг, сумын Засаг даргын тамгын газар нь:

А. “Сэлэнгэ Зөгий” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх

Б. ”Сэлэнгэ Зөгий” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөвт суулгаж санхүүжүүлэх.

В. Зөгийн өвчинтэй тэмцэх, үржлийн ажлыг сайжруулахад шаардагдах эм бэлдмэл, багаж материалын нөөц бий болгож захиран зарцуулах журмыг тогтооох.

7.3. Хүнс Хөдөө аж ахуйн газар нь:

А.Тухайн жилд Зөгийн аж ахуйн талаар хийгдэх ажлын захиалга даалгаврыг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

Б.Зөгийн аж ахуй эрхлэгчдийг мэргэшүүлэх, дадлага олгох, шинэ технологи эзэмшүүлэх сургалтанд хамруулах.

В.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулж, үр дүнг жил бүр нэгтгэн аймгийн Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнана.

7.4 Аймгийн газрын алба нь: Зөгийн бэлчээр олгох асуудлыг тухайн сумын Засаг даргын тамгын газартай хамтран шийдвэрлэнэ.

### **Найм. Зөгийн аж ахуй эрхлэх боломж**

Зөгийн аж ахуйг эрхлэхэд дараах 2 боломжийг ашиглах.

8.1. Хүнс хөдөө аж ахуйн газрын удирдлага, дэмжлэгтэйгээр зөгийн үржлийн аж ахуй байгуулж, эх зөгий бойжуулан ард иргэд, аж ахуйн нэгж байгууллагад нийлүүлэх.

8.2. Гадаад орноос зөгий импортлох ажлыг тусгай зөвшөөрлийн эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх.

### **Ес. Хөтөлбөрийн үр дүн**

9.1. Хөтөлбөрийн хугацаанд сум бүрд эх зөгий бойжуулах боломж бүрдэнэ.

9.2. Зөгий үржүүлэх өрх бүр зөгийн үржил, технологийн талаар мэдлэг эзэмшинэ.

9.3. Сум бүр 2010 онд 200-иас доошгүй бүл зөгийтэй болно.

9.4 Хөтөлбөр хэрэгжих дуусах 2015 онд нийт өрхийн 20 хувийг 15 бүл зөгийтэй болгож 48 тн бал үйлдвэрлэнэ. Энэ нь аймгийн хүн амын хэрэгцээний 29 хувийг хангана.

9.5. "Сэлэнгэ Зөгий" хөтөлбөр хэрэгжсэнээр иргэд аж ахуйн нэгжийн орлого нэмэгдэж хүүхэд, залуучууд эрүүл өсөн бойжих боломж бүрдэнэ.

9.6 Байгалийн болон таримал ургамлын ургац нэмэгдэж, бэлчээрийн талхагдал доройтол багасна.

9.7 Зөгий үржүүлэх орон нутгийн нөөц бүрдэнэ.

### **Арав. Удирдлага зохион байгуулалт**

10.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд ХХААГазар эрхэлж ажлын үр дүнг Засаг даргын зөвлөлд бүтэн жилээр тайлагна.

10.2. Сум багын түвшинд хөтөлбөрийн хэрэгжилтийг тухайн шатны засаг дарга хариуцан үр дүнг ХХААГазарт тайлагнана.

10.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлж жил бүрийн төлөвлөгөөг сум багын засаг дарга нар боловсруулж Хүнс, Хөдөө аж ахуйн газарт ирүүлэх бөгөөд аймгийн ИТХТ-ийн хурлаар баталж мөрдөж хэрэгжүүлнэ.

### **Арван нэг. Санхүүжилт**

11.1 Иргэн аж ахуй нэгжийн өөрийн хөрөнгө

11.2 Орон нутгийн төсвөөс хуваарилах хөрөнгө

11.3 Гадаад дотоодын төсөл хөтөлбөрөөс олгох зээл тусламж хөрөнгө оруулалт

### **Арван хоёр. Шалгуур үзүүлэлт**

Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр хэмжинэ

11.1 Шинээр байгуулагдсан зөгий үржлийн аж ахуйн тоо

11.2 Бойжуулж иргэдэд нийлүүлсэн эх зөгий бүлийн тоо

11.3 Таваарын болон үржлийн бүлийн тоо

11.4 Үйлдвэрлэсэн бал бусад бүтээгдэхүүний хэмжээ

11.5 Нэг бүлээс авсан балны хэмжээ

11.6 Өвөл хаврын бэлчээрийн ургамлын ургацын дээшлэлт, төрөл зүйлийн өөрчлөлт



Сэлэнгэ аймгийн ИТХ-ийн 2007 оны  
10-р сарын 10-ны өдрийн 69 тоот  
тогтоолын 2-р хавсралт

**Өрхийн аж ахуйн нөхцөлд Зөгийн аж ахуй  
эрхлэх зөвлөмж**

**Зорилго**

Байгалийн гаралтай экологийн цэвэр бүтээгдэхүүн Зөгийн бал үйлдвэрлэж чанар сайтай бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг хангах, аж ахуйн нэгж, иргэдэд зөгий аж ахуй эрхлэх технологи эзэмшүүлэх нь зөвлөмжийн зорилго юм.

**Зөгийн аж ахуйд шаардагдах техник хэрэгсэл**

Зөгий аж ахуйд тохилог дулаан өвөлжөө, зөгийн гэр, үйлдвэрлэл явуулах байр, хатан зөгий гаргах, сархиаг хэрэгсэл хадгалах байр зэргийг тусгайлан бэлтгэсэн байх шаардлагатай.

**Зөгий өвөлжөө**

Зөгийг хүйтнээс хамгаалж өвөлжүүлэхэд зориулагдсан байгууламжийг өвөлжөө гэнэ. Өвөлжөө нь 1-3 хэм дулаантай, 70-80 хувийн чийглэгтэй, зөгийн бүлийг дуу, чимээ, гэрэл нэвтрэхээс хамгаалагдсан байх нь зүйтэй. Өвөлжөө нь хэт чийглэг, гэрэлтэй байвал бал шингэрч, модон материал мууддаг, хуурайшвал бал талсжих, зөгий талсжих зэрэг зохисгүй байдал илэрч өвчин хортонд амархан нэрвэгддэг. Зөгийн өвөлжөөг байрлалаар нь газар дээрхи, хагас газар доорхи, газар доорхи гэж ангилдаг. Манай орны нөхцөлд газар доорхи өвөлжөө хамгийн тохиромжтой.

Зөгийн өвөлжөөг чимээ шуугиан багатай, малын хашаа, байрнаас зайдуу, нөмөр дулаан, хөрсний гүний ус 5 м-ээс доошгүй нарны тусгал сайтай орчинд байрлуулах нь зүйтэй. Өвөлжөөний тулгуур багануудыг 25-30 см голчтой гуалингаар хийж, 70-80 см гүнд суулгаж бэхэлнэ. Баганыхаа дээд хэсэгт 20-25 см голчтой гуалингаар нуруу тавьж, хөндлөн холбоос хийж өгнө. Ханыг 20 см голчтой шургаагаар хийх нь тохиромжтой. Модон эдлэлийг хар тосоор тослох зэргээр ялзралтаас хамгаалж, зузаан шавардаад нүүрсний үнс, хуурай бууцаар дулаалж чигжинэ.

Өвөлжөөний дээврийг хар цаас, шавраар хучиж, 50-70 см зузаан хуурай бууцаар дулаалж, дээврийн гадна талыг ус нэвтрэхээргүй шавардаж дээрээс нь шороогоор хучна.

Өвөлжөөний дотор гурван давхар банзан тавиурыг нэг бүл зөгийд 0.5 шоо метр оногдохоор бодож суурилуулна.

Зөгийг 10 дугаар сарын сүүлчээр өвөлжөөнд оруулж хавар 12-13 хэм дулаан болсон салхигүй үед гадаалуулна.

Зөгийг өвөлжөөнд байх хугацаанд 10-14 хоног тутамд үзлэг хийж, дулааны хэмийг нь тохируулж байх хэрэгтэй.

Зөгийн өвөлжөөг зун буюу намар барьж хатааж бэлдсэн байх нь зүйтэй.

### **Зөгийн гэр**

Зөгийг модон гэрт өсгөж үржүүлнэ. Зөгийн гэрийг дан, олон давхраат хэвтээ, хоёр давхраат гэж ангилдаг.

Манай орны нөхцөлд олон давхраат гэрийг хэрэглэдэг бөгөөд энэ нь зөгийг арчлахад тохиромжтой байдаг.

Зөгийн гэрийг 5 см-ээс доошгүй зузаантай нарс, хушин банзаар хийх нь тохиромжтой . Олон давхраат гэр нь салгаж авч болдог учир арчилгаа хийхэд хялбар байдаг.

### **Бусад тоног, хэрэгсэл**

Зөгийн аж ахуй эрхлэхэд дээрхээс гадна утуур, ховхчуур, эх хадгалах тор, идүүр, сүрэглэл барих сав, сэмж наах өнхрүүш, жаазанд татах төмөр утас, шөвөг, бахь, алх, гэрийн бэхэлгээ, лавны хутга, лавхайлуулах төхөөрөмж, бал юүлүүр зэрэг тоног төхөөрөмж шаардагдана.

### **Зөгийн суурь**

Зөгийг тодорхой тоогоор байрлуулсан нэгжийг зөгийн суурь гэнэ.

Зөгийн суурийг бэлчээрт ойр, балт ургамлын зүйлийн бүрдлээр баялаг, нөмөр, дулаан, наранд ээвэр газрыг сонгож байрлуулна. Суурийн агаар талаар мод сөөг тарьж өгөх нь салхинаас хамгаалах, зөгийг нисэхэд нь зүг чигээ олоход нь тусалдаг сайн талтай.

### **Зөгийн арчилгаа , маллагаа**

Зөгий нь таван хошуу мал шиг жилийн дөрвөн улирлын турш тэжээл, усалгаа шаарддаг амьтан юм.

Зөгийн амьдралыг идэвхитэй, тайван гэсэн 2 үед хуваана.

Идэвхитэй үе нь 3 дугаар сараас 10 дугаар сарын сүүлч, тайван үе нь 10 дугаар сарын сүүлчээс 3 дугаар сарын сүүлч хүртэл буюу зөгийн өвөлжөөнд байх хугацааг хамаарна.

Тайван үед шинээр үүр, багаж, хэрэгслэл хийх, засаж сэлбэх, угааж, ариутгах зэрэг зөгийн аж ахуйн бүх бэлтгэл ажлыг хийдэг.

Хаваржуулах бэлтгэлээ урьдчилан сайн хангасны үндсэн дээр хавар 3 дугаар сарын 20-ноос эхлэн нэг сарын дотор өвөлжөөнөөс гаргана. Хаваржуулалтын бэлтгэлд үүр засах, бал хураагч суурь, даавуун дэр, цаваг зэрэг орох бөгөөд нэг үүрэнд 10 суурь, 2 дэр, 1 цаваг ордог. Бэлтгэсэн үүрнүүдээ голын хөндийн бургас болон яргуй, өрөл, монос, үхрийн нүд, улаалзгана ургасан уулын ам, жалганд байрлуулна. Өөрөөр хэлбэл балт ургамал хамгийн эрт цэцэглэдэг газарт зөгийгөө бэлчээнэ гэсэн үг юм. Энэ үед авсан балыг “Таван сарын бал” гэж нэрлэдэг. Зөгийг зунд нь хошоонгор, шар хуаёс, шимтэглээ, маалинга, хүцэнгэ, гүзээлзгэнэ, төмөрдэй, тэмээн хөх зэрэг балт болон тоосонцорт ургамал элбэгтэй нуга, хөндий ойн цоорхойд байршуулах нь тохиромжтой. Намарт нь мангир, башир, үлд өвс, бэр цэцэг элбэгтэй хээр талд оторловол сайн байдаг.

Зөгий нь 5 км орчмоос балаа цуглуулдаг тул аль ч улиралд үүнийг бодолцон бэлчээрээ сонгох нь зүйтэй. Зөгий бас ус уудаг учир гол усанд ойр байх хэрэгтэй. Зөгий тарга хүчээ хэр сайн авсныг нь үүрэн доторхи суурь зөгийгөөр дүүрсэн эсэхээр нь мэддэг. Нэг үүрэн дэхь 10 суурины 8-аас дээшид нь зөгийгөөр дүүрсэн байвал тарга хүч сайн авчээ гэж үзнэ.

### **Зөгийг оторлох**

Зөгийн хүн орчны балт ургамалын тархалт, цэцэглэлтийн хугацааг сайн байх хэрэгтэй. Зөгийг нүүлгэхийн өмнө сархиагийг хөдөлгөөнгүй бэхэлж, их балтай сархиагийг үүрнээс авч нисгэвчийг сайн хаана. Гэрийн эд ангийг хооронд нь салахааргүй бэхэлнэ. Зөгийг шөнийн цагаар, бороотой үед өдрийн цагаар нүүлгэж болно. Зөгийн бүлийг тэвшээр өндөрлөсөн машинд 2-3 давхар ачиж, татлагаар сайн татна. Зөгий ачсан машин бартаатай замд 15 км цагаас илүүгүй хурдтай явна. Оторлохоор товлосон цэгт ирээд зөгийг аяархан буулгаж, байрлуулаад бүл бүрийн нисгэвчийг онгойлгоно. Шинэ сууринд услуур тавьж, гэрийн гаднах бэхэлгээг авч бүлээ дулаалах, цэгцлэх ажлыг хийнэ. Зөгийчин оторт явахдаа нүүдлийн сууц, пүү, зөгийчний багаж, хэрэгсэл, бал ялгуур, сэмж, утасласан жааз, нөөц гэр, сархиаг, хөдөлмөр хамгааллын хувцас зэргийг авна.

### Зөгийн аж ахуйн зардал

№	Хийгдэх ажил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Шаардагдах зардал	
				Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Зөгийн бүл	ш	15	300000	4560000
2	Байр барих	ш	1	500000	500000
3	Хөдөлмөр хамгааллын хувцас	ш	1	500000	500000
4	Зөгийн аж ахуйн тоног төхөөрөмж / зөгийн гэр, утуур, хавхлуур, их хадгалах тор, идүүр, сэмж наах, өнхрүүш, жаазанд татах утас, шөвөг, бахь, алх, лавны хутга, бал юүлүүр г.м /	Ком	1	100000	100000
	<b>ДҮН</b>				<b>515000</b>

### Тав. Борлуулалтын орлого

дд	Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	Тоо	Үнэ	
				Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Зөгийн бал	кг	150	10000	1500000
2	Зөгийн лав	кг	4	5000	20000
3	Зөгийн хор	гр	14	70000	98000
	Нийт дүн				2500000

### Зургаа Санхүүжилтийн эх үүсвэр

дд	Эх үүсвэрийн төрөл	Дүн
1	Өөрийн хөрөнгө	2000000

2	Зээл	3150000
Дүн		5150000

Тайлбар: Жил бүр 150 кг бал үйлдвэрлэж зах зээлд нийлүүлсэнээр төслийн хөрөнгө оруулалтыг 2.5 жилд бүрэн нөхөж цаашид ашигтай ажиллах боломжтой.

Долоо. Зөвлөмжийг хэрэгжүүлсний үр дүн

1. Зөгийн эрчимжсэн аж ахуй бий болно.
  2. Шилмэл үүлдрийн зөгийн бүл сонгон үржүүлж, сонирхогчдийг үржлийн эх зөгийгээр хангах боломж бүрдэнэ.
- Зөгийн арчилгаа маллагааг технологийн горимын дагуу явуулж, зөгийн үндсэн болон дайвар бүтээгдэхүүнийг бүрэн ашиглана.
- Балны гарцыг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.
- Орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрэнэ.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_